**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 14 өдөр Дугаар А/113 Улаанбаатар хот

Үерийн хариу арга хэмжээний
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, 32.1.9 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/174 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн нутаг дэвсгэрт үерийн хариу арга хэмжээг зохион байгуулах, нутгийн захиргааны байгууллагын бэлэн байдлыг хангах төлөвлөгөөг нэгдүгээр, хариу арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар дугаар, Гамшгаас хамгаалах алба, Мэргэжлийн ангийн хүч хэрэгслийг хуваарилан ажиллуулах төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2.Үерийн хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, шуурхай, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг дүүргийн аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үерийн хариу арга хэмжээг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА А.СҮХБОЛД

AJIL\2024 он ажил\захирамж

1123200325

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн
А/113 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

# ҮЕРИЙН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дүүргийн нутгийн захиргааны байгууллага, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиуд үерийн аюулаас урьдчилан сэргийлэх, бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэн, нөөц бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Хугацаа | Хамтран хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|---|---|---|---|
| **1. Дүүргийн Засаг даргын тамгын газар, Онцгой комисс** | | | | | |
| 1.1 | Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хөрөнгө гаргах, хохирол хэрэгцээний үнэлгээ хийх зэрэг холбогдох чиглэлээр захирамж болон тушаалын төслийг бэлтгэх, богино хугацаанд шийдвэрийг гаргуулах бэлтгэлийг хангах | Боловсруулах захирамж, тушаалын төсөл, тоо | 6 | 5, 6-р сард | ЗДТГ, ОБХ |
| 1.2 | Үерт өртөх эрсдэлтэй байршлыг иргэдэд тогтмол сэрэмжлүүлэн ажиллах | Зохион байгуулах арга хэмжээ, тоо | Тогтмол | 2, 3-р улиралд | ЗДТГ, ОБХ |
| 1.3 | Үерээс урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээний талаар зохион байгуулсан ажлыг олон нийтэд хүргэх | Зохион байгуулах арга хэмжээ, тоо | Тогтмол | 2, 3-р улиралд | ЗДТГ, ОБХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ |
| 1.4 | Ашиглалт, засвар, үйлчилгээний байгууллагуудын үерийн үед үүрэг гүйцэтгэх, техник хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх | Нэмэгдүүлэх техник хэрэгсэл, тоо | 2 | 2-р улиралд | ЗДТГ, ТХҮХ |
| 1.5 | Дүүргийн хэмжээнд үерийн аюулаас урьдчилан сэргийлэх далан суваг, ус зайлуулах хоолойд үзлэг шалгалт зохион байгуулах | Шалгалт хийсэн тоо | 3 | 2-р улиралд | ТХҮХ, ОБХ |
| 1.6 | Үерийн голомтод үүрэг гүйцэтгэх зориулалтаар хүн нэг бүрийн хамгаалах хувцас, усны гутал, “Оп” цув, | Бүрдүүлэх иж бүрдэл, | 50 | 2-р улиралд | ЗДТГ-ын СТСХ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | маск, бээлий зэрэг шаардлагатай материалын нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангуулах | тоо | | | |
| 1.7 | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудтай машин механизмыг татан ажиллуулах гэрээ байгуулах | Гэрээ байгуулах аж ахуйн нэгжийн тоо | 5 | 2-р улиралд | ТХҮХ, ОБХ |
| 1.8 | Орон сууцны барилга байгууламж аж ахуйн нэгжийн зоорийн давхарт үерийн аюулаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангуулах | Шалгалт хийсэн тоо | 2 | 2-р улиралд | ТХҮХ, ОБХ |
| 1.9 | Инженерийн хангамжийн ашиглалтын байгууллагуудтай яаралтай үед холбоо тогтоох бэлэн байдлыг хангуулах /Утасны жагсаалт бэлтгэх/, холбогдох байгууллагуудтай мэдээ, мэдээлэл солилцох | Тусгай зөвшөөрөлтэй ААНБ, тоо | 8 | 2-р улиралд | Инженерийн хангамжийн ашиглалтын байгууллага |
| 1.10 | Хариу арга хэмжээнд ажиллаж буй бие бүрэлдэхүүнийг чанартай хоол хүнсээр хангах аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулах | Гэрээ байгуулах аж ахуйн нэгжийн тоо | 3 | 2-р улиралд | ЗДТГ, ТХҮХ |
| 1.11 | Шаардлагатай бичиг хэрэг, компьютер, хэвлэгч төхөөрөмжтэй байрлаж ажиллах бэлэн байдлыг хангуулах | Томилгоожуулах албан хаагч, тоо | 3-аас доошгүй | 2-р улиралд | ДОК, ОБХ |
| | **2. Дүүргийн Онцгой байдлын хэлтэс** | | | | |
| 2.1 | Дүүргийн Онцгой комиссыг сургаж дадлагажуулах | Сургалтын тоо | 1 | 2-р улиралд | ЗДТГ |
| 2.2 | Гамшгаас хамгаалах албадад бэлэн байдлын үзлэг зохион байгуулах | Хамруулах алба тоо | 2 | 2-р улиралд | "Багахангай тохижилт" ОНӨААТҮГ |
| 2.3 | Гамшгаас хамгаалах алба, Мэргэжлийн ангийн хүч хэрэгслийг тодотгох ажлыг зохион байгуулах | Хамруулах алба, мэргэжлийн анги, тоо | 16 | 2-р улиралд | Гамшгаас хамгаалах албад |
| 2.4 | Түр орон байранд иргэдийг аюулт үзэгдэл, осол тохиолдсон үед байрлуулах бэлтгэлийг хангаж шаардлагатай хэрэгсэл /эвхдэг ор, хөнжил гудас, хоолны хэрэглэл/ бэлэн байдлыг шалгах, байгууллагуудтай гэрээ байгуулах | Бэлэн байдлыг шалгасан тоо | 2 | 1, 2-р улиралд | БТСХ, ХЦС сургууль |
| 2.5 | Дүүргийн хэмжээнд үерийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх | Үнэлгээний тоо | 1 | 2-р улиралд | ЗДТГ, ОБХ |
| | **3. Дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс** | | | | |
| 3.1 | Дайчилгаагаар ажиллах хүн хүч, техник хэрэгслийн судалгааг гаргах бэлэн байдал | Тодотгох судалгаа, тоо | 1 | 2-р улиралд | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хангуулах. /Гамшгийн үед хэв журам сахиулах, замын хөдөлгөөн зохицуулах албаны төлөвлөгөөнд тодотгол хийх/ | | | | |
| 3.2 | Үерийн голомтод байрлаж, үүрэг гүйцэтгэх тохиолдолд хамгаалалт, зохицуулалтын арга хэмжээ авах, аюулгүй байдлыг хангах. | Хамгаалалт зохион байгуулах байршил, тоо | 1 | Тухай бүр | Дүүргийн шуурхай штаб, Онцгой байдлын хэлтэс |
| | **Замын цагдаагийн хэсэг** | | | | |
| 3.3 | Үерийн эрсдэл бүхий байршлуудад замын хөдөлгөөн зохицуулах төлөвлөгөө боловсруулах | Төлөвлөлтийн тоо | 1 | 2-р улиралд | Дүүргийн шуурхай штаб, ОБХ |
| 3.4 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлийн алба хаагчдын хуваарь, томилгоог 1, 2-р ээлжээр боловсруулах, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах | - | - | 2-р улиралд | - |
| 3.5 | Тусгай үүргийн техник хэрэгслийг үерийн голомтод очих үеийн шуурхай байдлыг хангаж хөтөч тээврийн хэрэгслийн бэлэн байлгах | Хөтөч тээврийн хэрэгслийн тоо | 1 | 2-р улиралд | - |
| 3.6 | Үерийн голомтод ажиллах мэргэжлийн байгууллагын алба хаагч, ажилтны ажиллах нөхцөлийг бүрдүүлэх. /Замын хөдөлгөөний нөхцөл байдлыг зөв тодорхойлох, хөдөлгөөний урсгал, чиглэл хаах, өөрчлөх/ | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 2-р улиралд | Дүүргийн шуурхай штаб |
| 3.7 | Үерийн ажилд шаардагдах ачаа тээвэр хийгдэх үеийн шуурхай байдлыг хангах хөдөлгөөн зохицуулалтыг зохион байгуулах | - | - | 2-р улиралд | Онцгой байдлын хэлтэс |
| | **4. Дүүргийн Эрүүл мэндийн төв** | | | | |
| 4.1 | Үерийн аюулд нэрвэгсэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэх бэлэн байдлыг хангах зохион байгуулалтыг бүрдүүлж, яаралтай тусламжийн хэсэгт нөөцийг бүрдүүлж байршуулах. | Эм тарианы нөөцийг бүрдүүлсэн байна | 1 | 1, 2-р улиралд | НЭМҮТ |
| 4.2 | Нэрвэгдэгсдэд эмнэлгийн тусламж үзүүлэх /эрэмбэлэн ангилах, анхны тусламж үзүүлэх, тээвэрлэх/ багийг томилж, үүрэгжүүлэх | Томилох баг, тоо | 1 | 2-р улиралд | |
| 4.3 | Нэрвэгсдэд эмнэлгийн анхны тусламж үзүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хүн нэг бүрийн хамгаалах хувцас хэрэгслийн нөөц бүрдүүлэх | Нөөц бүрдүүлэлтийн багц | 1 | 2-р улиралд | |
| 4.4 | Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, техник | Хүч хэрэгслийн судалгааг гаргах | 1 | 2-р улиралд | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хэрэгслийн судалгааг гаргах, бэлэн байдлыг хангаж ажиллах. | | | | |
| 4.5 | Халдвараар өвчлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх эм бэлдмэлийг бэлтгэх, бэлэн байдлыг хангуулах | Халдварын эрсдэлээс сэргийлэх эм бэлдмэл, тоо | 200 хүн/тун | 2-р улиралд | ХӨСҮТ |
| 4.6 | Эмч, эмнэлгийн ажилчдад зориулсан дотоодын сургалтыг зохион байгуулах | Сургалтын тоо, ажилчдын тоо | 3 | 2-р улиралд | НЭМҮТ, ДОБХ |
| 4.7 | Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, зөвлөгөө, зөвлөмж бэлтгэж олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах. | Бэлтгэх зөвлөгөө, зөвлөмжийн тоо | 5 | 2-р улиралд | - |
| | **5. Дүүргийн Боловсролын хэлтэс** | | | | |
| 5.1 | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн заал, анги танхимыг болзошгүй аюулт үзэгдэл, ослын үед иргэдийг байрлуулах түр байрны нөөцөд авах судалгааг гаргах | - | 1 | 2-р улиралд | ЗДТГ, НХХ, ОБХ |
| | **6. Дүүргийн Газар зохион байгуулалтын алба** | | | | |
| 6.1 | Болзошгүй гамшгийн үед түр цугларах, нүүлгэн шилжүүлэх газрын байршлуудад түр нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах, зөвшөөрөлтэй иргэн, хуулийн этгээдийн асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэх, зөвшөөрөлгүй суурьшил үүсгэсэн иргэн, хуулийн этгээдийн зөрчил арилгаж, албадан нүүлгэх | Нүүлгэн шилжүүлсэн нэгж талбарын тоо | - | 2-р улиралд | ЗДТГ |
| | **7. "Ус суваг ашиглалтын товчоо"** | | | | |
| 7.1 | Шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийн судалгааг гаргаж, нөөцийг бүрдүүлэх | - | - | 1, 2-р улиралд | "Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ |
| 7.2 | Дайчлагдах хүн хүч, машин механизм, тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, бэлтгэл, бэлэн байдлыг хангах | Гаргах судалгаа, тоо | 1 | 1, 2-р улиралд | |
| 7.3 | Ус соруулах помп, насос, хоолойны хэвийн найдвартай ажиллагааг хангах, сорох, шахах хоолойн нөөц бүрдүүлэх | - | - | 1-р улиралд | |
| 7.4 | Зөөврийн усаар хангах түгээх автомашиныг бэлэн байдлыг хангуулах | Ус түгээх автомашин, тоо | 1 | Тухай бүр | ЗДТГ, ОБХ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **8. “Багахангай тохижилт” ОНӨААТҮГ** | | | | | |
| 8.1 | Томилгоожсон мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангах, шаардлагатай багаж хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлэх. | - | - | 2-р улиралд | ЗДТГ, ТХҮХ |
| 8.2 | Ажиллах хүн хүч, машин механизм, тоног төхөөрөмжийн судалгаа гаргаж, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах | Нэмэгдүүлэх машин механизм, тоо | 2 | 2-р улиралд | ЗДТГ, ТХҮХ |
| **9. “Илч-Орд” ОНӨААТҮГ** | | | | | |
| 9.1 | Томилгоожсон мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангах, шаардлагатай багаж хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлэх. | - | - | 2-р улиралд | ЗДТГ, ТХҮХ |
| 9.2 | Дулааны шугам сүлжээнд үзлэг шалгалт хийж, гэмтлийг засварлах ажлыг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангах | Удирдамжийн тоо | 1 | 2-р улиралд | ЗДТГ, ТХҮХ |
| **10. “Налайх эрчим хүчний салбар” Өндөр толгой хэсэг** | | | | | |
| 10.1 | Үерт өртөж болзошгүй цахилгаан хангамжийн барилга байгууламж, шугам сүлжээний судалгаа гаргах | Хийх судалгаа, тоо | 1 | 2-р улиралд | Налайх ХҮТ |
| 10.2 | Тулгуурын бэхэлгээ даац, травис бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээ авах | Зохион байгуулах арга хэмжээ, тоо | 1 | Тухай бүр | |
| 10.3 | Дэд станц хуваарилах байгууламжийн ус зайлуулах байгууламж, хаалга дээврийг бүрэн бүтэн байдлыг хангах | Зохион байгуулах ээлжит бус үзлэг, тоо | Шаардлагатай үед | Тухай бүр | |
| 10.4 | Шар усны үерт өртөж болзошгүй шугам дэд станцуудад үзлэг шалгалт зохион байгуулах, аюулгүй байдлыг хангах | Удирдамжийн тоо | 1 | 2-р улиралд | |
| 10.5 | Цахилгаан тэжээлийг нөөц эх үүсвэрээс хангах нөхцөл, боломжийг бүрдүүлэх бэлэн байдлыг хангах | - | - | 2-р улиралд | |
| 10.6 | Улсын онц чухал объект, эрүүл мэндийн байгууллагуудыг эрчим хүчээр тасралтгүй хангах арга хэмжээ, авах | - | - | 2-р улиралд | |

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн
А/113 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

## ҮЕРИЙН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хариу арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа | Хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| **1. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр** | | | | | |
| 1.1 | Үер болсон дуудлагыг хүлээн авч дүүргийн Онцгой комиссын нарийн бичгийн даргад мэдээллийг шуурхай хүргэх | Мэдээлэл хүлээн авсан даруйд | ОБХ | МШУТ | - |
| 1.2 | Үерийн үүссэн нөхцөл байдлын талаарх анхдагч мэдээллийг шуурхай авч дүүргийн Онцгой комиссын дарга (түүний түр эзгүйд Онцгой комиссын орлогч дарга)-д танилцуулах | Мэдээлэл хүлээн авсан даруйд | ОБХ | МШУТ | - |
| 1.3 | Үерийн голомтод хүрч очин өртсөн иргэдийг эрэн хайх, аврах ажиллагааг эхлүүлэх | 30 мин дотор | ОБХ | ЦХ, ЭМТ | - |
| 1.4 | Дүүргийн Онцгой комиссын гишүүд, Үер, ус цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдэл ослын үед ажиллах шуурхай "Ажлын хэсэг"-ийн бүрэлдэхүүнийг "Яаралтай цуглар" дохиогоор ЗДТГ-ын хурлын зааланд цуглуулах | 1 цагийн дотор | ОБХ | ТЗУХ | - |
| 1.5 | Мэдээллийг хүлээн авч тодотгон дүүргийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын даргад яаралтай мэдэгдэж дүүргийн Онцгой комиссыг яаралтай хуралдуулах | 2 цагийн дотор | ОБХ | ЗДТГ | - |
| 1.6 | Эрх бүхий албан тушаалтан байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу үерийн голомтын бүсээр тогтоосон гудамж, зам, уулзвар, гарцын зорчих хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээг шуурхай | 2 цагийн дотор | ЦХ | ЗЦТ | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулах | | | | |
| 1.7 | Дүүргийн Онцгой комиссын даргын тушаалаар “Шуурхай штаб, (бүлэг)”-ийг байгуулж ажиллах нөхцөл шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах | 2 цагийн дотор | ЗДТГ, ТЗУХ | ОБХ | Зөөврийн компьютер, принтер, дотуур үүрэн холбооны утас, ажлын зураг, самбар, зөөврийн дэлгэц, бичиг хэргийн хэрэгсэл |
| 1.8 | Нисгэгчгүй нисгэгч төхөөрөмж хөөргөж, нөхцөл байдлын бодит мэдээ, мэдээллээр хангах | 2 цагийн дотор | ОБХ | ЦХ | - |
| 1.9 | “Шуурхай штаб, (бүлэг)”-ийг үерийн голомтод байгуулан ажиллах тохиолдолд цахилгаан, харилцаа холбоо, сүлжээ, шаардлагатай тоног төхөөрөмж зэргээр хангаж, ажиллах нөхцлийг бүрдүүлэх | 2 цагийн дотор | ОБХ | ДОК | - |
| 1.10 | Үерийн нөхцөл байдлын талаар нийслэлийн Онцгой комисс, Улсын Онцгой комисст мэдээлэл хүргүүлэх | 2 цагийн дотор | ОБХ | ДОК | - |
| 1.11 | Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай дүүргийн Засаг даргын захирамжийг боловсруулж батлуулах | 4 цагийн дотор | ЗДТГ, ТЗУХ | ДОК | - |
| 1.12 | Гамшгийн голомтын бүс хамарсан хүрээ, учирсан хохирол, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, голомтод үүрэг гүйцэтгэж байгаа болон нөөц хүн хүч, техникийн судалгаа гарган удирдлагад танилцуулах | 4 цаг тутамд | Шуурхай штаб | ДОК | - |
| 1.13 | Дүүргийн Гамшгаас хамгаалах албад, Мэргэжлийн ангийн ажлын уялдаа холбоо, нэгдсэн удирдлагаар хангах | Тогтмол | Шуурхай штаб, ЗДТГ | ДОК | - |
| 1.14 | Ус, цаг уур, үерлэсэн усны түвшний мэдээллийг холбогдох байгууллагаас тогтмол цагт авч дүүргийн Онцгой комиссын дарга болон гишүүд, Шуурхай штабыг мэдээллээр хангах | 4 цаг тутамд | Шуурхай штаб | УЦУОШГ, ЗДТГ | - |
| 1.15 | Үерийн нөхцөл байдлыг үнэлэн цаашид авах арга хэмжээг төлөвлөх | 4 цагийн дотор | НОК, ДОК | Шуурхай штаб | - |
| 1.16 | Хөдөлгөөнт удирдлагын байрыг техник хэрэгслээр тоноглон бэлтгэж, бэлэн байдлыг хангах | 4 цагийн дотор | Шуурхай штаб | НОК, ДОК | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1.17 | Үерийн голомтод шаардлагатай хүч хэрэгслийг төрийн өмчийн болон аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан гэрээний дагуу татан төвлөрүүлж, оновчтой хуваарилж хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах | 4 цагийн дотор | Шуурхай штаб | УСАТ, "Багахангай тохижилт", "Илч-Орд" ОНӨААТҮГ, УБТЗ-ын БЗАҮ-2 анги | 1-р ээлжинд дугуйт экскаватор-1, ковш-1, ачааны автомашин /16 тн дээш/ 1, бобкат 1, нийт 4 машин механизм |
| 1.18 | | Шаардлагатай үед | | | 2-р ээлжинд ковш-2, ачааны автомашин 2 нийт 4 машин механизм |
| 1.20 | Дүүргийн нутаг дэвсгэрийн ажлын зургийг бэлтгэж байршуулах | 5 цагийн дотор | Шуурхай штаб | ЗДТГ, ОБХ | - |
| 1.21 | Үерийн эрсдэлтэй болон өртсөн бүсийн байршил, хамарсан талбайн хэмжээ, холбогдох мэдээ, мэдээллийг газрын зурагт оруулах, байршуулах /Цахим болон цаасан суурьтай/ | 5 цагийн дотор | Шуурхай штаб | ЗДТГ, ОБХ | - |
| 1.22 | Өртсөн хороо, өрх, хүн ам, аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийг нарийвчлан гаргах, зурагт оруулах | 6 цагийн дотор | Шуурхай штаб | ЗДТГ | - |
| 1.23 | Үерт өртсөн нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэдийн судалгааг гаргаж, шаардлагатай тусламж, дэмжлэгийг үзүүлэх ажлыг зохион байгуулах | 6 цагийн дотор | ДОК | ЗДТГ, НХХ | - |
| 1.24 | Үерт өртсөн өрхүүдэд анхны тусламж, нийгэм сэтгэлзүй, бараа материалын дэмжлэг үзүүлэх | 7 цагийн дотор | ДУЗН | ДОК | (Шалгуур үзүүлэлтийн дагуу 100 хүртэлх өрхийг сонгоно.) |
| 1.25 | Орон гэргүй болсон иргэдийн бүртгэл, мэдээллийг нэгтгэн боловсруулж, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах бүлэгт мэдээллийг хүргүүлэх | 7 цагийн дотор | ЗДТГ | ДОК | - |
| 1.26 | Хохирлын урьдчилсан үнэлгээ (дэд бүтэц, айл өрх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан хохирол)-г хийх ажлыг зохион байгуулах | 10 хоногийн дотор | ДОК | ЗДТГ, СТСХ | - |
| | **2. Холбоо, зарлан мэдээллийн чиглэлээр** | | | | |
| 2.1 | Шуурхай мэдээ мэдээлэл солилцох зорилгоор | 2 цагийн | ОБХ | ЗДТГ | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | дотоод сүлжээ үүсгэн холбоо зохион байгуулах | дотор | | | |
| 2.2 | Радио холбоо зохион байгуулж, үерийн голомтын бүс, Шуурхай штаб хооронд холбоо зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэх | 2 цагийн дотор | ОБХ | ДОК | Гар станц 8 ш |
| 2.3 | Үерийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, урьдчилан сэргийлэх зөвлөгөө, зөвлөмж, мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэх | Тухай бүр | ЗДТГ | ДОК | - |
| **3. Нөөц, хангалтын талаар** | | | | | |
| 3.1 | Үерийн хариу арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах зардлын тооцоог нэгтгэн боловсруулж дүүргийн Засаг даргын захирамжийг батлуулан шийдвэрлүүлэх арга хэмжээг зохион байгуулах | Тухай бүр | ЗДТГ, СТСХ | ДОК | - |
| 3.2 | Дүүргийн Онцгой комисст хандив тусламжаар ирүүлсэн бараа материалыг хүлээн авч бүртгэх, хадгалах, тайлагнах голомтод үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдад хуваарилах ажлыг зохион байгуулах | Тухай бүр | ДОК | ЗДТГ, ААТ | - |
| 3.3 | Иргэн, аж ахуйн нэгж, байгуулагаас ирүүлсэн хандив, тусламжийн мэдээллийг иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж, тайлагнах, зарцуулалтыг талархал илэрхийлэх, таниулах арга хэмжээг зохион байгуулах | Тухай бүр | ДОК | ЗДТГ, ААТ | - |
| 3.4 | Гэрээ байгуулсан аж ахуйн нэгж, байгууллагаас шатахуун, хий, шатах, тослох материалыг үерийн голомтод ажиллаж байгаа шуурхай албаны автомашин, механизмыг шатах тослох материалаар хангах ажлыг зохион байгуулж, санхүүжилтийг олгох | Тухай бүр | ДОК | ЗДТГ, Ерөнхий нягтлан бодогч | “Трансгайд сервис” ХХК-ны газрын тосны агуулах, “Тэс петролиум” ХХК-ны ШТС-28 салбараас АИ-92 шатахуун 2 тн, дизель 5 тн |
| 3.5 | Үерийн хариу арга хэмжээнд ажиллаж байгаа машин механизмд түлш, шатахууныг зөөвөрлөх ажлыг зохион байгуулах | Тухай бүр | ДОК | ЗДТГ | - |
| 3.6 | Үерийн голомтод үүрэг гүйцэтгэж байгаа болон Шуурхай штабын бие бүрэлдэхүүнийг чанартай хоол хүнсээр хангах ажлыг зохион байгуулах | 6 цаг тутамд | ЗДТГ | ТХҮХ | Гэрээ байгуулсан хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | үйлчилгээ нийт 4 аж ахуйн нэгж, иргэдээс 1 ээлжинд 50 хоол авч хуваарлах |
| 3.7 | Үерийн голомтод ажиллаж байгаа шуурхай бүлэг, аврагчид, нэрвэгдэгсдийг хоол, хүнсээр хангах байр бэлтгэх | 4 цагийн дотор | ЗДТГ, НХХ | ДОК | - |
| 3.8 | Үерийн голомтод үүрэг гүйцэтгэх ажилтан, албан хаагчдыг шаардлагатай хамгаалах хувцас, хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах | 4 цагийн дотор | ЗДТГ | ДОК, СТСХ | Хамгаалах хувцас, шуудай, хүрз, амны хаалт, бээлий, усны гутал, цув тус бүр 50 ширхэг |
| | **4. Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах чиглэлээр** | | | | |
| 4.1 | Онцгой байдлын албанд ирсэн дуудлага, мэдээллийн дагуу иргэдийг аврах ажиллагаа зохион байгуулах | Дуудлага авсан даруйд | ОБХ | ГХА, МА | Гал түймэр унтраах, аврах 80 ангийн томилгоот 8 алба хаагч, 2 автомашин, 1 мотопомп |
| 4.2 | Үерийн усанд боогдсон иргэдийг аюулгүй талбайд шилжүүлэх | 1 цагийн дотор | ОБХ | ЦХ | 12 алба хаагч, 2 автомашин |
| 4.3 | Сураггүй алга болсон иргэдийг (тээврийн хэрэгсэл, явган)-аар эрэн хайх ажиллагааг зохион байгуулах | 1 цагийн дотор | ОБХ | ЗДТГ, ЦХ | 16 алба хаагч, 4 автомашин, 1 дрон |
| 4.4 | Үерийн болон тогтоол усанд осолдсон буцалтгүй нэрвэгдэгчийг гаргаж холбогдох байгууллагад хүлээлгэн өгөх | Олсноос хойш 30 мин дотор | ОБХ | ЦХ | 8 алба хаагч, 2 автомашин |
| | **5. Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр** | | | | |
| 5.1 | Нэрвэгдэгсдэд эмнэлгийн анхны болон нарийн мэргэжлийн тусламж үзүүлэх | 15 минутын дотор | ЭМТ | - | - |
| 5.2 | Нэрвэгдэгсдэд эмнэлэг хүртэлх эмнэлгийн тусламж үйлчилгээг 1-р ээлжид тухайн өдөр үүрэг гүйцэтгэж буй 1 түргэн тусламжийн багаас үндсэн үйл ажиллагааг доголдуулалгүйгээр голомтод ойр багийг шилжүүлэн ажиллуулах | Тухай бүр | ЭМТ | | Эмч, сувилагч жолооч бүхий 1 түргэн тусламжийн баг |
| 5.3 | 2-р ээлжид мэргэжлийн ангиудаас эмнэлгийн | Тухай бүр | ЭМТ | ДОК | Эмч, сувилагч, |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | тусламжийн багийг нэмэлтээр ажиллуулж, дэмжлэг үзүүлэх | | | | жолооч, түргэн тусламжийн автомашин бүхий 2 эмнэлгийн тусламжийн баг |
| 5.4 | Үерийн голомтод ажиллаж байгаа болон нэрвэгдсэн иргэдийн эрүүл мэндэд хяналт тавьж, гэдэсний халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эм хуваарилах ажлыг зохион байгуулах | Тухай бүр | ЭМТ | НЭМГ | 1-р ээлжид 200 ширхэг |
| 5.5 | Үерийн аюулд өртсөн иргэдэд сэтгэлзүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх | Тогтмол | ЭМТ | ДУЗН | - |
| 5.6 | Эм, эмнэлгийн хэрэгслээр хангах үйл ажиллагааг мэргэжлийн ангиудтай хамтран зохион байгуулах | Тухай бүр | ЭМТ | "Монос трейд" ХХК эмийн сан | - |
| 5.7 | Үерийн улмаас үүсэж болзошгүй гэдэсний халдварт өвчний тандалт судалгааг гүйцэтгэх, урьдчилан зөвлөгөө, зөвлөмжийг иргэд, олон нийтэд хүргэх арга хэмжээг зохион байгуулах | Тухай бүр | ЭМТ | ЗДТГ, ДОК | - |
| 5.8 | Халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулах, хяналт тавих | Тухай бүр | ЭМТ | НЭМГ | - |
| | **6. Цахилгаан хангамжийн чиглэлээр** | | | | |
| 6.1 | Цахилгаан хангамжийн барилга байгууламж, шугам сүлжээ, тоноглолын аюулгүй байдлыг хангах | Тогтмол | "Өндөр толгой" ЭХС | "УБЦТС" ТӨХК-ийн Налайх төв | - |
| 6.2 | Цахилгаан эрчим хүч, цахилгаан дамжуулах шугам сүлжээ, дэд станцыг хуваарилах байгууламж зэрэг хэрэглэгчийг болзошгүй эрсдэлээс сэргийлж, түр цахилгаан салгах, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах | Тогтмол | "Өндөр толгой" ЭХС | "УБЦТС" ТӨХК-ийн Налайх төв | - |
| 6.3 | 1 дүгээр ээлжийн хүч хэрэгсэл гэр хороолол, орон сууцны айл өрх, аж ахуйн нэгжийн цахилгаан эрчим хүчний эрсдэлээс сэргийлж таслалт хийх, сэргээн засварлах, гэмтэл устгах, хэрэглэгчийг залгах ажлыг гүйцэтгэх | 2 цагийн дотор | Багахангай "Өндөр толгой" ЭХС | "УБЦТС" ТӨХК-ийн Налайх төв | 5 алба хаагч, 1 бонго, 1 сагстай өргөгч нийт 2 автомашинтай |
| 6.4 | 2 дугаар ээлжийн хүч хэрэгсэл гэр хороолол, орон сууцны айл өрх, аж ахуйн нэгжийн цахилгаан эрчим хүчний эрсдэлээс сэргийлж таслалт хийх, сэргээн засварлах, гэмтэл устгах, хэрэглэгчийг залгах ажлыг гүйцэтгэх | Шаардлагатай үед | Багахангай ЦШС-ний хэсэг | УБТЗ-ын ЭХУХ 1-р анги | 6 алба хаагч, 1 фургон автомашинтай |
| 6.5 | Цахилгаан хангамж тасалдсан улсын онц чухал | Шаардлагатай | Багахангай | УБЦТС" ТӨХК- | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | объект, эрүүл мэндийн байгууллага зэрэг нэн шаардлагатай байгууллагуудыг цахилгаанаар хангах арга хэмжээ авах | үед | "Өндөр толгой" ЭХС, ЦШС-ний хэсэг | ийн Налайх төв, УБТЗ-ын ЭХУХ 1-р анги | |
| 6.6 | Цахилгаан тэжээлийг нөөц эх үүсвэрээс хангах нөхцөл боломжийг бүрдүүлэх, шалгах | Шаардлагатай үед | Багахангай "Өндөр толгой" ЭХС | ОБХ, УСАТ, Илч-Орд ОНӨААТҮГ | - |
| **7. Нийтийн хэв журам сахиулах, замын хөдөлгөөн зохицуулах чиглэлээр** | | | | | |
| 7.1 | Үерт өртсөн тээврийн хэрэгслийг зөөж, тээвэрлэх, хэв журам сахиулах үйл ажиллагаанд 1-р ээлжийн хүч хэрэгслийг ажиллуулах | Тухай бүр | Замын цагдаагийн хэсэг | ЦХ | 5 алба хаагч, 2 шуурхай албаны автомашин |
| 7.2 | 2-р ээлжийн хүч хэрэгслийг нүүлгэн шилжүүлэх үеийн аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах, эмх замбараагүй байдал гаргуулахгүй байх арга хэмжээг авах | Шаардлагатай үед | ЦХ | ДОК | 8 алба хаагч, 2 шуурхай албаны автомашин |
| 7.3 | "Шуурхай штаб"-ын байранд 24 цагаар 3 ээлжинд харуулын үүрэг гүйцэтгүүлэн ажилтан алба хаагч, иргэдийг орох, гарах хөдөлгөөнд хяналт тавих | Шуурхай штаб байгуулагдсан даруйд | ЦХ | ДОК | - |
| 7.4 | 1-р ээлжийн хүч хэрэгслийг замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөн зохицуулах, зам хаах, урсгал чиг өөрчлөх, түр зөөврийн тэмдэг тэмдэглэгээ байрлуулахад ажиллуулах | Тухай бүр | Замын цагдаагийн хэсэг | ЦХ | 4 алба хаагч, 2 шуурхай албаны автомашин |
| 7.5 | Үер усны гамшгийн үед ажиллах тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж болон элс, хайрга тээвэрлэж яваа том оврын ачааны авто машиныг маршрутын дагуу хөдөлгөөнд оролцох үеийн аюулгүй байдлыг хангах | Тухай бүр | Замын цагдаагийн хэсэг | ЦХ | - |
| **8. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, барилга байгууламжийн зоорийн давхрын усыг соруулах, хог хаягдал, цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн чиглэлээр** | | | | | |
| **8.1 Гудамж, зам талбай, барилга байгууламжийн зоорийн давхрын усыг соруулах** | | | | | |
| 8.1.1 | Орон сууцнуудын сууц өмчлөгчдийн холбоодийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, шаардлагатай үед шуурхай холбоо тогтоож, холбогдох арга хэмжээг зохион байгуулах | Тухай бүр | ТХҮХ | ЗДТГ | - |
| 8.1.2 | УСАТ-ны 1-р ээлжийн 6 алба хаагч, 1 машин механизм, 6 тоног төхөөрөмжтэй ажиллах | 2 цагийн дотор ажиллуулж эхлэх | УСАТ | ДОК | Зөөврийн усны машин-1, Цахилгаан үүсгүүр-1, |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | Ус соруулах помп-1 |
| 8.1.3 | Онцгой байдлын хэлтсийн 2-р ээлжийн хүч хэрэгсэл үерийн ус соруулах ажиллагааг зохион байгуулах | Шаардлагатай үед | ОБХ | ДОК | Цахилгаан үүсгүүр-1, Ус соруулах помп-1 |
| 8.1.4 | Багахангайн ЦШС-ний хэсэг 1-р ээлжийн хүч хэрэгсэл үерийн ус соруулах ажиллагааг зохион байгуулах | Шаардлагатай үед | УБТЗ-ын ЭХУХ 1-р анги | ДОК | Цахилгаан үүсгүүр-1, Ус соруулах помп-1 |
| 8.1.5 | УСАТ-ны 2-р ээлжийн 8 алба хаагч, 1 машин механизм, 4 тоног төхөөрөмжтэй ажиллах | Шаардлагатай үед | УСАТ | ДОК | Цахилгаан үүсгүүр-1, Ус соруулах помп-2 |
| 8.1.6 | Үерт өртсөн хэсэг дэх инженерийн шугам сүлжээний аюулгүй байдал, үйл ажиллагааг доголдуулахгүй байх, урьдчилан сэргийлэх болон нөхөн сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлэх | Тухай бүр | "Илч-Орд" ОНӨААТҮГ УБТЗ-ын БЗҮА | ДОК | - |
| **8.2 Хог хаягдал, цэвэрлэгээ, халдваргүйтгэл** | | | | | |
| 8.2.1 | Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, барилга, байгууламжийн зоорийн давхрын лаг шаврыг зөөж, цэвэрлэх, тээвэрлэх, зайлуулах ажлыг зохион байгуулах | Ус соруулсны дараа | "Багахангай тохижилт" ОНӨААТҮГ | ТХҮХ | - |
| 8.2.2 | Авто зам, хорооллын дунд замын лаг шавар, үүссэн хог хаягдлыг цэвэрлэх | 1-р ээлж | "Багахангай тохижилт" ОНӨААТҮГ | ТХҮХ | 12 ажилтан, ковш 1, бобкат-1, хог тээврийн автомашин 1 нийт 3 машин механизм |
| 8.2.3 | Явган болон туслах замын цэвэрлэгээ үйлчилгээг зохион байгуулах | 2-р ээлж | "Багахангай тохижилт" ОНӨААТҮГ | ТХҮХ | 10 ажилтан, ковш 1, дугуйт экскаватор-1, хог тээврийн автомашин 1 нийт 3 машин механизм |
| 8.2.4 | Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулах | Цэвэрлэгээ дууссаны | "Багахангай гэрэлтүүлэг, | ТХҮХ | Хамтран ажиллах гэрээ байгуулсан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | дараа | ногоон байгууламж" ОНӨААТҮГ | | 1 ААНБ, 6 ажилтан, тусгай зориулалтын техник тоног төхөөрөмж 1, 2 төрлийн 20 тонн бодисоор халдваргүйжүүлэлт хийх |
| 8.2.5 | Үерийн улмаас хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, цэвэрлэх арга хэмжээг зохион байгуулах | Тухай бүр | "Багахангай тохижилт" ОНӨААТҮГ | ТХҮХ, МЭТ | - |
| | **9. Ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр** | | | | |
| 9.1 | Үерт өртсөн хүн ам, айл өрхийг зөөврийн ундны усаар хангах ажлыг зохион байгуулах | Тухай бүр | УСАТ | ЗДТГ | Зөөврийн усны машин-1, УТБ-4 |
| 9.2 | Ундны усны эх үүсвэр болон дахин дамжуулах насос станцуудаас дээж авч шинжилгээнд хамруулж, холбогдох арга хэмжээг зохион байгуулах | Тухай бүр | УСАТ | ЗДТГ | Цэг салбар-7 |
| 9.3 | Бохир усны шугам сүлжээний хэвийн ажиллагааг хангах үйл ажиллагааг зохион байгуулах | Тухай бүр | УСАТ | ЗДТГ | - |
| | **10. Нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах** | | | | |
| 10.1 | Дүүргийн Онцгой комиссын хурлын шийдвэрийг үндэслэн Засаг даргын "Нүүлгэн шилжүүлэх тухай" захирамж боловсруулан батлуулах | Тухай бүр | ТЗУХ | ДОК | - |
| 10.2 | Нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулахад шаардагдах зардлын тооцоог гаргаж, холбогдох шийдвэрийг гаргуулах санхүүжүүлэх | Тухай бүр | СТСХ | ДОК | - |
| 10.3 | Үерт өртөж, орон гэргүй болсон иргэдийг бэлтгэсэн түр орон байранд нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах | Тухай бүр | ДОК | ЗДТГ | 100 хүнийг байрлуулахаар холбогдох хэрэгслээр 2 түр орон байрыг хангасан. |
| 10.4 | Үерийн аюулд өртөж, орон гэргүй болсон иргэдийг түр орон байр руу зөөвөрлөж, байршуулах ажлыг зохион байгуулах | Тухай бүр | ДОК | ЗДТГ | 2 автобус |
| 10.5 | Нүүлгэн шилжүүлэх үеийн аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах, эмх замбараагүй | Тухай бүр | ЦХ | ДОК | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | байдал гаргуулахгүй байх арга хэмжээг авах | | | | |
| 10.6 | Үерт нэрвэгдэн орон гэргүй болсон иргэдийг эхний ээлжинд сургууль, спорт заалны түр байранд байрлуулах ажлыг төлөвлөн, хуваарилах ажлыг зохион байгуулах | Тухай бүр | ЗДТГ | ДОК | Нийт 3 сургуулийн спорт зааланд 300 хүн, 2 цэцэрлэгийн байранд 200 хүн, нийт 500 хүнийг байрлуулахаар төлөвлөсөн |
| 10.7 | 2 дахь ээлжинд түр байраар томилгоожсон зочид буудал, аж ахуйн нэгж байгууллагатай зөвшилцөн зохион байгуулах | Шаардлагатай үед | ЗДТГ, ТХҮХ | ДОК | 1 зочид буудал, 4 ААНБ нийт 50 хүнийг байрлуулах боломжтой. |
| 10.8 | Орон гэргүй болж, түр байранд байрласан нэрвэгдэгсдийг хоол хүнс, шаардлагатай бол ундны усаар хангах ажлыг зохион байгуулах | Иргэд байрласнаас хойш | ТХҮХ | ДОК | Гэрээт хүнсний дэлгүүр 6, Хоол, хүнсээр хангах ААНБ 2 |
| 10.9 | Түр орон байранд байрлаж буй иргэдэд эмнэлгийн тусламж үзүүлэх | Тухай бүр | ЭМТ | ЗДТГ | - |
| 10.10 | Иргэдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд сайн дурын иргэдийг ажиллуулах зохион байгуулалтад оруулах | Иргэдийг байрласнаас хойш | ДУЗН | ДОК | - |
| 10.11 | Үерт өртсөн гэр хороолол, айл өрхийн судалгаа гарган шинэ суурьшлын бүсэд газар олгох асуудлыг холбогдох байгууллагатай зөвшилцөж, өртсөн айл өрхийг суурьшуулах байршлыг тодорхойлох | Тухай бүр | ГЗБА | ЗДТГ | - |
| 10.12 | Иргэдийг нүүлгэн шилжүүлж, байршуулах гэр барих ажлыг зохион байгуулах | Тухай бүр | ЗДТГ | ДОК | - |
| 10.13 | Нүүлгэн шилжүүлэх ажиллагаанд үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүнийг бэлтгэл бэлэн байдлыг хангуулж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангах | Тухай бүр | ОБХ, ЦХ | ДОК | - |
| 10.14 | Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний дагуу тогтоосон байршил, аюулгүй бүс рүү хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний гэр бүлийн гишүүдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах | Тухай бүр | ОБХ, ЦХ | ДОК | - |
| 10.15 | Иргэд шаардлагатай бичиг баримт, хүнс, хувцас | Тухай бүр | ЗДТГ | ДОК | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хэрэглэлийг бэлтгэн, цугларах газарт тогтоосон хугацаанд очиж, нүүлгэн шилжүүлэлт хийх томилгоот бүлгүүдийн заавар, зөвлөмжийг чанд сахиж нүүн шилжих тухай мэдээллийг хүргэх | | | | |

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн
01/113 дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

# ҮЕРИЙН ҮЕД ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБА, МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУД ӨӨРИЙН ХҮЧ ХЭРЭГСЛЭЭР АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

| д/д | Ажиллах хүн, техник, багаж хэрэгслийн нэр | 1-р ээлжинд ажиллуулах хүч хэрэгслийн тоо | 2-р ээлжинд ажиллуулах хүч хэрэгслийн тоо | 3-р ээлжинд ажиллуулах хүч хэрэгслийн тоо | Нийт | Хүчин чадал, үзүүлэлт, зориулалт | Дэлгэрэнгүй мэдээлэл (Улсын дугаар, загвар, марк) | Хариуцах албан хаагчийн мэдээлэл, утас | Шатахууны төрөл | 1 цагт зарцуулах шатахуун (мото цаг) | 100 км-т зарцуулах шатахуун (литр) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭС** | | | | | | | | | | | |
| 1 | Ажиллах алба хаагч | 6 | 8 | 10 | **24** | | | д/х Г.Ганзориг 91109184 | | | |
| 2 | Мотопомп | 1 | 1 | 0 | **2** | 1 цагт 1.8 тонн ус сорох | Ямаха | х/ч Г.Отгонбаатар 89011853 | АИ-92 | 10 л | |
| 3 | Тээврийн хэрэгсэл | 1 | 1 | 1 | **3** | Тусгай зориулалтын | Фургон 62-60 УБЧ, Ланд-70 11-56 УКА, Ланд-78 11-59 УЕУ | а/а Х.Энхжаргал, 88211284<br>а/а Б.Доржпүрэв, 89041912<br>а/ч Б.Пүрэвхүү 98099444 | АИ-92, ДТ | | 18 |
| **УС СУВАГ АШИГЛАЛТЫН ТОВЧОО** | | | | | | | | | | | |
| 4 | Ажиллах алба хаагч | 5 | 5 | 5 | 15 | | | Товчооны дарга Н.Батсайхан 96000634 | | | |
| 5 | Мотопомп | 1 | | | 1 | 1 цагт 2 тонн ус сорох | Хонда гоном насос | Ш.Балдорж 91270099 | АИ-92 | 5 л | |
| 6 | Тээврийн хэрэгсэл | 1 | | | 1 | | Бонго 41-79 УНТ | Б.Гантулга 96117732 | ДТ | | 17 |
| **ЦАГДААГИЙН ХЭЛТЭС** | | | | | | | | | | | |
| 7 | Ажиллах алба хаагч | 4 | 4 | 4 | **12** | | | хур Т.Лхагвасүрэн 95950500 | | | |
| 8 | Тээврийн хэрэгсэл | 1 | 1 | 1 | **3** | Тусгай зориулалтын | Киарио 23-61 УАТ<br>Патрол 04-36 УНҮ<br>Фургон 30-23 УНҮ | а/а Д.Хонгорзул 95117425,<br>а/ч Т.Амарбаатар 96340449 | А-92, ДТ | | Киа рио 10<br>Патрол 25<br>Фургон 25 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ | | | | | | | | | | | |
| 9 | Ажиллах алба хаагч | 3 | 3 | 3 | 9 | | | Дарга Х.Ганбат 88892022 | | | |
| 10 | Мотопомп | 3 | 1 | | 4 | 1 цагт 1.5 тонн ус сорох | Гоном, помп насос | Нярав Б.Энхцэцэг 99642162 | АИ-92 | 5 л | |
| 11 | Тээврийн хэрэгсэл | 1 | 1 | 1 | 3 | Эмнэлгийн тусламж үйлчилгээ | Urban 89-66 УНҮ, Starex 71-65 УНИ, Delica 02-52 УЕМ | Д.Амараа 99784313 Э.Мөнхбат 99661374 | АИ-92 | | Urban 18 Starex 15 Delica 15 |
| БАГАХАНГАЙ ТОХИЖИЛТ ОНӨААТҮГ | | | | | | | | | | | |
| 12 | Ажиллах алба хаагч | 8 | 10 | 15 | 33 | | | Захирал Б.Гэрэлмаа 99008292 | | | |
| 13 | Тээврийн хэрэгсэл | 1 | 1 | 1 | 3 | Тусгай зориулалтын | Ковш 30 94-41УН Дугуйт экскаватор 02-17 УР, Бонго-3 34-61УБН | М.Мөнхбаяр 88091281, Б.Баатархүү 80800195 Т.Амарсанаа 88728080 | ДТ | Ковш 15 Дугуйт экскаватор 20 | Бонго 14 |
| ИЛЧ-ОРД ОНӨААТҮГ | | | | | | | | | | | |
| 14 | Ажиллах алба хаагч | 6 | 10 | 2 | 18 | | | Захирал Д.Гантулга 88069422 | | | |
| 15 | Тээврийн хэрэгсэл | 1 | 1 | 1 | 3 | Тусгай зориулалтын | Ковш 50 98-63УР NORTHBENZ-15-89УАН, Toyota Velifire 22-84УЕН | Г.Даваатогтох 96110689 Б.Даваасүрэн 86113809 | ДТ, А-92 | 25 | Northbenz-45, Toyota Velifire-11 |
| БАГАХАНГАЙ ГЭРЭЛТҮҮЛЭГ, НОГООН БАЙГУУЛАМЖ ОНӨААТҮГ | | | | | | | | | | | |
| 16 | Ажиллах алба хаагч | 3 | 5 | 3 | 11 | | | | | | |
| 17 | Тээврийн хэрэгсэл | 1 | 2 | 2 | 5 | Тусгай зориулалтын | isizu 16-11 УНП, Боб кат 36-25УН, Өргөгч кран 72-16УАХ, ус тээвэрлэгч 12-91УАН, Alpard 64-92 УНВ | Л.Бадрах 88047892, Б.Алтанхуяг 99782911, Д.Тэрболд 99838959, Х.Шаравжамц 89957170 | ДТ | 15 | isizu 18 Өргөгч кран 20 ус тээвэрлэгч 25 Alpard 12 |
| ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР | | | | | | | | | | | |
| 18 | Ажиллах алба хаагч | 7 | 7 | 10 | 24 | | | Тамгын газрын дарга Л.Санжийжамц 88111277 | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | Тээврийн хэрэгсэл | 1 | 1 | 1 | 3 | Албан хэрэгцээнд | Toyota hais 20-07 УБЯ Соната7 71-51 УНӨ, Hyundai County автобус 85-41УБГ | ААТЭ П.Дэлгэр 88033627, Ч.Нямдорж 99009659, А.Үүрцайх 88811862 | А-92, Газ, ДТ | | Toyota hais 18 Соната 8 Hyundai County автобус 18 |
| "ӨНДӨР ТОЛГОЙ" ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАР | | | | | | | | | | | |
| 20 | Ажиллах алба хаагч | 5 | | | 5 | | | Мастер С.Алтанхүү 88091223 | | | |
| 21 | Тээврийн хэрэгсэл | 1 | | | 1 | Шуурхай албаны | Бонго-3 37-18 УБН | Д.Цэрэнпил 95223181 | ДТ | | 16 |
| МАЛ ЭМНЭЛГИЙН ТАСАГ | | | | | | | | | | | |
| 22 | Ажиллах алба хаагч | 2 | | | 2 | | | Тасгийн дарга Д.Шүрэн-Эрдэнэ 95977920 | | | |
| 23 | Тээврийн хэрэгсэл | 1 | | | 1 | Суудлын | Sonata-7, 64-96 УНӨ | Тархвар зүйч П.Цэрэнням 88611194 | АИ-92 | | 11.2 |
| БАГАХАНГАЙ БЗАҮ-АНГИ АШИГЛАЛТЫН ЦЕХ | | | | | | | | | | | |
| 24 | Ажиллах алба хаагч | 4 | 4 | | 8 | | | Мастер М.Даваадорж 95116839 | | | |
| 25 | Тээврийн хэрэгсэл | 1 | | | 1 | Ачааны | Бонго 72-22 УБЯ | Н.Алтансух 99522699 | ДТ | | 14 |
| БЗАҮ-АНГИ БАГАХАНГАЙ ЗУУХ | | | | | | | | | | | |
| 26 | Ажиллах алба хаагч | 3 | 3 | 3 | 9 | | | Механик Б.Дуламсүрэн 99037530 | | | |
| 27 | Мотопомп | 1 | 1 | 1 | 3 | 1 цагт 1.5 тонн ус сорох | Гоном насос | ЦТТ слесарь А.Эрдэнэбат 85111645 | | | |
| 28 | Тээврийн хэрэгсэл | 1 | | | 1 | | Ковш 40, 15-56УН | Э.Алтанхуяг 85111497 | ДТ | 20 | |
| ЭХУХ-ИЙН 1-Р АНГИ БАГАХАНГАЙ ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ХЭСЭГ | | | | | | | | | | | |
| 29 | Ажиллах алба хаагч | 5 | 5 | | 10 | | | Мастер Я.Түдэв 86114731 | | | |
| 30 | Тээврийн хэрэгсэл | 1 | | | 1 | Шуурхай албаны | Фургон 39-13 УАА | С.Тулга 89050754 | АИ-92 | | 18 |
| | Нийт ажиллах алба хаагч | 61 | 64 | 55 | 180 | | | | | | |
| | Нийт мотопомп | 6 | 3 | 1 | 10 | | | | | | |
| | Тээврийн хэрэгсэл | 11 | 6 | 6 | 23 | | | | | | |